

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ГҮТГЭХ
ДОРМЖЛОХТОЙ ХОЛБООТОЙ
ЗААЛТУУДАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ШААРДЛАГА**

Доромжлох гэмт хэрэг

ЭРҮҮГИЙН ХУУЛИНД

- “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” /2008 оны 02 сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон/ 110 дугаар зүйл

Гүтгэх гэмт хэрэг

ЭРҮҮГИЙН ХУУЛИНД

- “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”. 111 дүгээр зүйлийн 111.1.

ЭРҮҮГИЙН ХУУЛИНД

- “Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”. 111 дүгээр зүйлийн 111.2.

ЭРҮҮГИЙН ХУУЛИНД

- “Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол ...”. 111 дүгээр зүйлийн 111.3.

ЭРХ

- **Нэр төр, алдар хүндтэй байх,**
- **Уг нэр төр, алдар хүндээ хамгаалуулах
буюу зөрчигдсөн эрхээ сэргээлгэх,**
- **Учирсан гэм хорыг арилгуулах гэх мэт**

ЭРХ

- Нэр төртэй байх,
- Нэр төрөө хамгаалуулах,
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй байх,

**“ГҮТГЭЛЭГ, ДОРОМЖЛОЛ ГЭМТ
ХЭРЭГ МӨН ҮҮ” төсөл**

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААГААР

- **Босни-Герцоговини 2002 онд,**
- **Гүрж 2004 онд,**
- **Гана 2001 онд,**
- **Того 2004 онд,**
- **Шри-Ланка 2002 онд,**
- **Украйна 2001 онд тус тус эрүүгийн хуулиасаа гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл, заалтуудаа хасчээ.**

- **“Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй” Үндсэн хуулийн 16 дугаар зүйл**

ЭРҮҮГИЙН ХУУЛИНД

- **“Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”
Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйл.**

ИРГЭНИЙ ХУУЛИНД

- “Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” 21 дүгээр зүйл.

2008 оны байдлаар

- **Нэр төр, алдар хүндээ сэргээлгэхийг хүссэн 39 иргэний хэрэг шийдвэрлэсэн.**
- **Гүтгэсэн, доромжилсон гэх төрлийн 5 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн.**

- **Уг 5 эрүүгийн хэргийг бүгдийг нь Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр зүйлчилсэн.**
- **Нийт 10 хохирогч байгаагаас 3 нь жирийн иргэн.**
- **Бусад нь улс төр, төрийн алба, бизнесийн салбарт тус тус хамаарах хүмүүс.**

- **Хариуцлагаас зайлсхийх,**
- **Шүүмжлэгчийг айлгах,**
- **Дахин шүүмжлүүлэхгүй байлгах,**

САЙН ТАЛ

- **Доромжлох буюу Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлээр зүйлчилсэн тохиолдол 2008 онд бүртгэгдээгүй.**

ГАДААД УЛСУУДАД

- **Австрали энэ төрлийн гэмт хэрэгт хамгийн сүүлд 50 гаруй жилийн өмнө хорих ял хэрэглэсэн,**
- **Норвеги 1933 онд,**
- **Итали хамгийн сүүлд 1950 онд хорих ял оногдуулж байсан байна.**

Анхаарал тавьсанд баярлалаа